

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
(2023 оны жилийн эцсийн байдлаар)

2023 оны 10 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр сая төгрөг)	Нийт хөрөнгийн хэмжээ(сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтод			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
									2023 он				
									Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (Сая.төг)	Төсвийн (Гүйцэтгэл (сая.төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	
ТАВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО													
5.1 Нийслэлийн ногоон байгууламжийг сайжруулах оновчтой менежментийг хэрэгжүүлэн, хотыг цэцэрлэгжүүлэх, ойжуулах, тохижилт бүхий гудамж, талбайг бий болгож, иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.													
1	5.1.2 Хотын тоосжилтыг бууруулж, иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ.	209	5.1.2.1.Иргэд, олон нийтэд биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, амарч тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор стандартад нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбайг байгуулна.	2021-2024	УБЗАА ХСХГ Дүүргү үд	УНТ	21,7 45.7	Стандартад нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбай 23.	Стандартад нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбайг 9-өөр нэмэгдүүлсэн байна.	5,40 0.0	-	1.Хотын стандарт, хяналтын газрын даргын 2023 оны 02-13-04/023/03 дугаартай “Стандартын шаардлага хангахгүй эрсдэлтэй хүүхдийн тоглоомын талбайд урьдчилсан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу нийт 474 тоглоомын талбайг батлагдсан хяналтын хуудсаар шалгаж, хүүхдийн тоглоомын талбайн өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийг тодруулж, улсын байцаагчийн 88 зөвлөмж боловсруулан 474 байршилд хүргүүлсэн. Мөн судалгаанд хамрагдсан 974 хүүхдийн тоглоомын талбайн өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийг тодруулах зорилгоор НХОГ, НӨХГ, Нийслэлийн дүүргүүдийн Засаг	100

	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
												<p>дарга нарт 2023 оны 05 дугаар 15-ны өдрийн 01/460-469 дугаартай 86 хуудас хавсралт бүхий 11 албан бичгийг хүргүүлж, ирүүлсэн судалгааг нэгтгэсэн.</p> <p>2. Нийслэлийн хэмжээнд баригдсан 79 байршилд улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулав. Энэ ажлын хүрээнд "UCS1405B:2022 Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага"-ыг хангуулахаар захиалагч болон гүйцэтгэгч компанид холбогдох зөвлөмж, чиглэлийг хүргүүлэн ажиллаж байна.</p>	
5.3 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангана.													
2	5.3.4. Хүн ам төвлөрөн суурьшсан бүс нутаг, хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн эрэл хайгуулын судалгааг улсын болон бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, эрэлт хэрэгцээ, захиалгад үндэслэн хийж, газрын доорх усны ашиглах боломжит нөөцийг тогтоох ажлыг хэрэгжүүлнэ.	257	Ундны усны эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тодорхойлж, хил хязгаарын дагуу стандарт хангасан хашаа барьж, эрүүл ахуйн бүсийг хамгаална.	2022-2024	УСУГ ХСХГ	Нийслэлийн төсөв	-	-	Ундны усны эх үүсвэрийг хамгаалах 8 км хашаа барьсан байна.	1098.4	-	<p>1.Ундны усны эрүүл ахуйн хил хязгаарын дагуу стандарт, шаардлагад нийцсэн хашааг төлөвлөх талаар Ус сувгийн удирдах газарт санал, зөвлөмжийг өгсөн. Өгөгдсөн зөвлөмжийн дагуу 13 км хашааг тус байгууллагын төсвөөр засаж шинэчлэхээр шийдвэрлэсэн. Шинэ хашаа барих хөрөнгө батлагдаагүй учраас хэрэгжих боломжгүй болсон байна.</p> <p>2.Ундны усны хамгаалалтын бүсийг тусгай хэрэгцээнд авах талаар Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд дараах саналуудыг хүргүүлээд байна. Үүнд:</p> <p>- Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/139 дүгээр захирамжаар Ундны усны эх үүсвэрийн хориглолт болон хязгаарлалтын бүсийн талаар арга хэмжээний</p>	90

	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
												санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт Байгаль орчны стандартын хэлтсийн дарга орж, ундны усны эх үүсвэрийг хамгаалалтад авах тухай журам, тогтоолын төсөлд 3 саналыг 03 дугаар сарын 24-ний өдөр 01/230 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. - Сэлбэ, Дунд голыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах хамгаалалтын бүсийг тогтоох, цаашид мөрдөх дэглэм, горимд холбогдох саналыг 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдөр 01/918 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	
3	5.3.6.Нийслэлийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, аюулгүй байдлыг хангах стандартыг мөрдүүлнэ.	267	5.3.6.1.Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, хотын стандарт, норм, дүрмийг боловсруулж, мөрдүүлнэ	2021-2024	ХСХГ УСУГ НБОГ	НТ	200.0	-	Ундны усны эх үүсвэрийг хамгаалах, Үерийн усны барилга байгууламж, ус хуримтлуулах хөв цөөрөм /биосвайл/ үүсгэх, ус дахин ашиглах тухай удирдамж, баталсан 2 гарын авлагыг иргэд ААНБ-уудад сурталчлан таниулсан байна.	50.0	-	Газрын даргын 2023 оны А/32 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг "Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтад тавигдах шаардлага", "Хөв цөөрөм үүсгэх болон хур тундасны усыг хуримтлуулах, дахин ашиглахад тавигдах шаардлага" хотын стандартын төслүүдийг хянан хэлэлцэж тухайн хотын стандартын төслийг 3 дугаар ээлжийн жагсаалтад оруулан, хяналтын уншлага, засвар оруулан сайжруулсан. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 20 дугаар хуралдаанд танилцуулсан. Төслийг хянан тохиолдуулах ажлын хэсэг байгуулан 2024 оны 02 дугаар сарын 15-ны дотор Зөвлөлийн хуралдаанд эргэн танилцуулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барихаар шийдвэрлэсэн. Дээрх хотын стандартын төсөлд иргэд, олон нийтээс санал авахаар	70

	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
												байгууллагын standard.ub.gov.mn цахим хуудсанд байршуулсан.	
4		268	5.3.6.1.Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, хотын стандарт, норм, дүрмийг боловсруулж, мөрдүүлнэ	2021-2024	ХСХГ УБЗАА	НТ	150.0	-	Ногоон байгууламжийн техникийн ерөнхий шаардлага, төлөвлөлт хийх удирдамж, 2 арга зүйн баримт бичиг боловсруулсан байна.	50.0	-	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 20 дугаар тогтоолоор “Ногоон байгууламж” бүлгийн 5 хотын стандарт батлагдсан бөгөөд “Орон сууцны хороолол дахь ногоон байгууламжийн ерөнхий шаардлага”-аар гарын авлага боловсруулж байна.	70
5		269	5.3.6.1.Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, хотын стандарт, норм, дүрмийг боловсруулж, мөрдүүлнэ	2022-2023	ХСХГ УБЗАА	НТ	50.0	-	Хот доторх оршуулгын үйл ажиллагаа явуулдаг газрын орчны цэцэрлэгүүллтийн орчны аюулгүй байдлын баримт бичгийн төслийг батлуулсан байна.	20.0	-	Хотын стандартын төслийг боловсруулан Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 20 дугаар хуралдаанд танилцуулсан. Төслийг хянан тохиолдуулах ажлын хэсэг байгуулан 2024 оны 02 дугаар сарын 15-ны дотор Зөвлөлийн хуралдаанд эргэн танилцуулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барихаар шийдвэрлэсэн. Дээрх хотын стандартын төсөлд иргэд, олон нийтээс санал авахаар байгууллагын standard.ub.gov.mn цахим хуудсанд байршуулсан.	90
6		270	5.3.6.1.Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, хотын стандарт, норм, дүрмийг боловсруулж, мөрдүүлнэ	2022-2023	ХСХГ НБОГ	НТ	50.0	-	Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын хөрсөнд дахин сэргээлт хийх ерөнхий шаардлага, удирдамж	20.0	-	Газрын даргын 2023 оны А/32 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж тус гарын авлагыг хянан тохиолдуулж, шинэчлэгдсэн эрх зүйн баримт бичгийг тусган засвар сайжруулалт хийсэн. Цаашид Нийслэлийн Байгаль орчны газартай хамтран энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад гарын авлагыг цахим хэлбэрээр түгээх арга хэмжээг зохион байгуулна.	70

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	
								арга зүйн баримт бичгийн төслийг батлуулсан байна.					
6.1. Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрөлийг задалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологи нэвтрүүлнэ.													
7	6.1.3.Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн санг өргөжүүлэн иргэд, олон нийтэд нээлттэй болгон, тэгш хүртээмжийг нэмэгдүүлнэ.	283	6.1.3.1.Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгоно.	2022-2023	ХСХГ НМТГ	НТ	400.0	-	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн системийг бүрэн ашиглалтад оруулсан байна.	200.0		Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 01 дүгээр албан даалгавар, "Шил" ажиллагааны хүрээнд Нийслэлийн хэмжээнд ашиглалтад орсон нийт 883 барилга байгууламжийн комиссын дүгнэлт, холбогдох мэдээллийг нэгтгэн www.shilen.gov.mn -д байршуулахаар Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. Үүнд: - 2009-2012 онд ашиглалтад орсон 155 барилгын мэдээллийг Үндэсний Архивын газрын баримтаас шүүж нэгтгэсэн. - 2020-2023 онд ашиглалтад орсон 728 барилгын мэдээллийг байгууллагын цахим архив, мэдээллийн сангаас шүүж нэгтгэсэн.	90
8	6.1.5.Хотын стандарт, норм дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	297	6.1.5.1.Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрддөг стандартыг хангуулах шаардлагуудыг боловсруулж мөрдүүлнэ.	2021-2024	ХСХГ	НТ	533.5	Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрддөг стандартыг хангуулах 22 багц боловсруулсан.	Стандартыг ханлуулах 5 багц шаардлагыг боловсруулсан байна.	122.0	-	1.Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрдөх хотын стандартын төслийг боловсруулан 2022 онд 9 бүлгийн 38, 2023 онд 7 бүлгийн 14 хотын стандартыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан. 2.Хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжаар удирдамж, нэгдсэн төлөвлөгөө батлуулсан. Төлөвлөгөөнд хотын стандартыг сурталчлах, зөвлөмж арга зүйгээр	90

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
											<p>хангах, судалгаа хийх, хяналт шалгалт гэсэн үндсэн 4 чиглэлээр нийт 126 арга хэмжээ тусган хэрэгжүүлж ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хотын стандартын талаарх мэдлэг, ойлголт өгөх сургалтыг 18 удаа зохион байгуулж нийт 1821 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөллийг хамруулсан. - Нийслэлийн хэмжээнд барилга угсралтын ажил гүйцэтгэж буй нийт 698 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийсэн. Үүнээс 27 аж ахуйн нэгжид албан шаардлага хүргүүлж, зөвшөөрөлгүй 3 аж ахуйн нэгж, байгууллага, 5 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 17.500.000 төгрөгийн торгууль ноогдуулсан. - Нийслэлийн хэмжээнд нийт 382 байршилд барилгын түр байгаагаас 197 байршлын 751 объектод хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар улсын /ахлах/ байцаагчийн 117 зөвлөмж, 27 аж ахуйн нэгж байгууллагад албан шаардлага хүргүүлж барилгын түр хашааны стандартыг хангуулсан. - Батлагдсан ерөнхий төлөвлөгөөг мөрдөж ажиллах тухай 2023 оны 01/157 дугаартай албан мэдэгдлийг Хот байгуулалт, хөгжлийн газар, Орон сууцны бодлогын газар, мөн зураг төслийн 127 байгууллагуудад хүргүүлж, холбогдох норм ба дүрмийг зөрчиж олгосон зөвшөөрлийг цуцлах талаар 47 мэдэгдэл хүргүүлж, 3 байршилд улсын байцаагчийн дүгнэлт гарган Нийслэлийн Засаг даргын захирамжаар түр түдгэлзүүлж, 	

	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
												зөрчилтэй 2 ААНБ-д Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээг авч, зөрчлийг арилгуулсан.	
9		298	6.1.5.2.Төрийн болон нийгмийн үйлчилгээний барилгыг хүртээмжтэй дэд бүтцийн стандартад нийцүүлнэ.	2022-2024	НОСК ХСХГ НХБХГ	-	-	Стандартад нийцсэн төрийн болон нийгмийн үйлчилгээний 40 барилга байна.	Төрийн болон нийгмийн үйлчилгээний 45 барилгыг стандартад нийцүүлсэн байна.	-	-	Төрийн болон нийгмийн үйлчилгээний барилгыг хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжийн хүрээнд худалдаа, үйлчилгээний байгууллагын гадна орчин, хаягийн байгууламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжтэй байдалд хяналт шалгалт хийж, 95 аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөмж хүргүүлж 35 худалдаа үйлчилгээний байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэний налуу замыг стандартын дагуу хийж, тохижуулсан байна. 2. Барилгын тухай хуульд заагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан байх талаар Улсын ахлах байцаагчийн мэдэгдлийг 127 зураг төсөл зохиогч ААН-уудад хүргүүлсэн. 3. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1116 дугаар захирамжийн хүрээнд үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 397 аж ахуйн нэгж, байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн налуу зам /пандус/ хийх талаар зөвлөмж хүргүүлсэн. 4. Төрийн болон нийгмийн үйлчилгээний 43 барилгыг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй, стандартын	100


1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
											шаардлагын дагуу болгох үүрэг даалгавар өгч, биелэлтийг хянаж байнгын ашиглалтад оруулсан.	
Дундаж биелэлт:												85.5

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



С.ТӨМӨРДУЛАМ

Э.ДАВААХАТАН

Г.ЭНХЭЭ

М.ГАЧМАА